

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН: ӨНӨӨГИЙН  
БАЙДАЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

2019 оны 5 дугаар сар 20

**АГУУЛГА**

ОРШИЛ .....	2
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	2
Хууль эрх зүйн орчин .....	4
Гааль, худалдааны тарифын түвшин .....	5
Тээвэр, транзит тээврийн орчин .....	6
СОРИЛТ, ХҮНДРЭЛҮҮД, ШИЙДЭЛ .....	6
Бүтээмжтэй ажлын байрны хэрэгцээ.....	6
Бэлдсэн мэргэжилтнүүдээ ашиглах шаардлага.....	7
Дэд бүтцийн сул хөгжил хамгийн том сорилт.....	7
Дотоод нөөц бололцоог дайчлах нь бас нэг сорилт.....	7
Санхүүгийн нөөц ашиглах сорилт .....	8
САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....	9
Хавсралтууд .....	12

Илтгэгч: С. Бадрал, Д. Даваасамбуу

## **ОРШИЛ**

Монгол бол гадаад худалдаанаас бараг 100% хамааралтай цөөн улсын нэг юм. Иймээс гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх асуудал нэн тэргүүний зорилт болохыг Монголын нийгэм бүхэлдээ хүлээн зөвшөөрч, гадаад бодлогынхоо суурь үндэс болгох учиртай байна. Ийм байх ёстойг Япон, Герман, Нидерланд, БНСУ, Чех зэрэг олон олон орны жишээ харуулдаг.

Гадаад худалдаанд төвлөрсөн чамбай гадаад бодлоготой орнууд хөгжлийн манлайд хүрдгийг монголчууд бид анзаарч, сургамж, үлгэр авах нь чухал юм.

Дэлхий дахины асуудлыг шийдвэрлэхэд онцгой үүрэг бүхий хоёр хөрштэй Монгол Улс хариуцлагатай, чадавхитай, жигнэгдсэн (weighted) бодлого, үйл хөдлөлтэй байхыг хичээж, хөршийн ба гуравдахь хөршийн харилцааг эрхэмлэдэг билээ. Чингэхдээ худалдааны бодлогод онцгой анхаарал тавих цаг үе нь ирсэн байна.

Монголбанкнаас төгрөгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр өнгөрсөн онд зохион байгуулан хийлгэсэн гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, зарим бүтээгдэхүүний (ноолуур, арьс шир, мах, зэс, нүүрс, цахилгааны) экспортыг нэмэгдүүлэх тухай судалгаануудын зарим үр дүнгээс энэхүү илтгэлээрээ дамжуулан танилцуулж байна.

Дэлхий дахинаа таваарын бүтээгдэхүүн буюу коммодитисийн ач холбогдол нэмэгдсэн, цаашид ч улам өснө гэсэн итгэлтэй байна. Ялангуяа Монголд элбэг байгаа мал аж ахуйн түүхий эд, зэс болон эрчим хүчний уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийг түшиглэсэн нэмүү өртгийн сүлжээг улс орон даяар болон олон улсын хэмжээнд үүсгэн хөгжүүлэх боломж манай бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын өмнө нээлттэй байна.

## **ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Монгол Улсын хөгжлийн ололт амжилтыг тоочин ярихыг илүүц гэж үзэж цөөн тоо баримтыг дэлгэн ярихыг хичээе.

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2018 оны байдлаар \$12.9 тэрбум болж, түүний дотор экспорт \$7 тэрбум болсон байна ([Хүснэгт №1](#)). Энэ нь бараг Монгол улсын ДНБ-тэй тэнцэж буй хэрэг юм.

Манай Улсын төлбөрийн тэнцэл ихэнх тохиолдолд алдагдалтай байгаа бөгөөд 2018 оны хувьд урсгал ба хөрөнгийн тэнцэл 2.1 тэрбум долларын алдагдалтай байна ([Хүснэгт №2](#)). Хөгжлийн шаардлага, хэрэгцээний улмаас олон жилийн туршид энэхүү алдагдал их бага хэмжээгээр гарч байсан нь Монголын гадаад зээл, гадаадын хөрөнгө оруулалт (ХО)-ыг нэмэгдүүлэхэд хүргэсэн байна.

Өнгөрсөн оны эцсийн байдлаар гадаадын нийт зээлийн үлдэгдэл 28.7 тэрбум доллар, үүнээс компани хоорондын өр 9.2 тэрбум ам доллар байна.

Нийт зээлийн дотор Засгийн газрын зээлийн өрийн үлдэгдэл 7.2 тэрбум доллар, үүнээс бонд гаргах замаар бий болгосон өрийн үлдэгдэл 2.9 тэрбум байна. ([Хүснэгт №3](#)).

Үлдэх нь үндсэндээ 1990 оноос хойшхи хөгжлийн албан ёсны гэрээ хэлэлцээрүүдээр түнш орнууд, олон улсын байгууллагууд (ОУБ-ууд)-аас авсан зээл байна ([Хүснэгт №4](#)).

Гадаадын хөрөнгө оруулалт 2018 оны эцэст дээр дурдсан компани хоорондын зээлийг оролцуулснаар \$20.2 тэрбум доллар байна. Үүний дийлэнх буюу 14,6 тэрбум нь уул уурхайн салбарт оржээ. Үүний үр дүнд зэсийн баяжмалын экспорт 1 тэрбум доллароос 2 тэрбум, 2003 оноос экспортод зориулан олборлож эхэлсэн нүүрсний орлого өнгөрсөн онд 3 тэрбум ам доллар хүрсэн бөгөөд цаана нь газрын тос, цайр, төмөр, ураны салбарын хөрөнгө оруулалт их бий.

Оюутолгой, Тавантолгой зэрэг уул уурхайн үйлдвэрүүдэд хөрөнгө оруулалт хийгдэж, бүтээн байгуулалт өрнөсөн 2011-2013, 2017-2018 онуудад импорт, үйлчилгээ жил дутам 2-3 тэрбум доллароор өсч, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж байжээ. Энэ нь Монголд гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийг шингээх үйлдвэрлэлийн бааз, ажиллах хүчний хүрэлцээ чадавхи муу байгаагийн илэрхийлэл юм.

Хоёрдахь дүгнэлт бол Монгол Улсын экспортын дийлэнх нь уул уурхай, МАА-н түүхий эд байна.

Сүүлийн жилүүдэд боловсруулсан нүүрс, хөнгөн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн экспортлох боломж нэмэгдэж байна. Гэхдээ монголын эдийн засгийн анхдагч салбар болох МАА-д валют олох ихээхэн нөөцийг дутуу ашигласан хэвээр байна. Ялангуяа хонины ноос, арьс ширний зах зээлийн хангалт, үнийн түвшин нэн доогуур байна.

Монгол Улсын малын тоо өсөж, өнгөрсөн оны 66.5 сая болсон, үүнээс хонь 30.5, ямаа 27.1, үхэр 4.4, адуу 3.9 сая тэмээ 0.5 сая хүрчээ. Энэ 66.5 сая малаас гарах үндсэн түүхий эдийг бүрэн ашиглана гэвэл мах 434.6 мянган тонн, хонины ноос 33 мянган тонн, ямааны ноолуур 10.9 мянган тонн, арьс, шир 15 сая ширхэг болохоор байна. Эдгээрийг бүгдийг нь цуглуулж эргэлтэд оруулна гэвэл ойролцоогоор 3 их наяд гаруй төгрөг буюу 1.1 тэрбум ам доллар гарах юм. Нэг малчин өрхөд жил бүр дундажаар 17-20 сая төгрөг ногдохоор байна. ([Хүснэгт №5](#)). Малаас энэхүү ашиг шим жил бүхэн гардаг бөгөөд Монголчууд цөөхүүлээ болохоор дотооддоо ашиглах нь хязгаартай, ихэнхийг гадаад зах зах зээлд чиглүүлэх учиртай. Энд алдаа гаргавал ямар байдалд хүрдгийг Эмээлтийн зах дээрх борлуулалтгүй арьс ширний өнөөгийн бөөгнөрөл харууллаа.

Өдгөө мал аж ахуйн түүхий эдийн ойролцоогоор 20-30%-г дотоодын үйлдвэрүүдэд боловсруулан, бэлэн бүтээгдэхүүн болгон экспортод гаргадаг гэсэн судалгаа байна. Үүнд олон шалтгаан бий байх аа. Олон улсын зах зээл дээр өрсөлдөх хэмжээний чанартай бүтээгдэхүүн харьцангуй бага, техник технологийн шинэчлэл бүрэн хийгдээгүй гэдэг шалтгаан тооцдог ч хамгийн гол нь МАА-н түүхий эдийг цуглуулж бэлтгэхэд шаардагдах хөрөнгө дутагдаж байгаа нь МАА-н бүтээгдэхүүнийг түүхийгээр гаргаж байгаагийн гол шалтгаан нь болж байна. Үүний дээр малын түүхий эдийг эрэлттэй, үнэд хүргэх арга ухаанаа бид бүрэн олж чадахгүй байна.

Монгол Улсын бэлчээрийн мал цэвэр агаарт үргэлж хөдөлгөөнтэй бэлчээрлэж, байгальд зэрлэг ургаж байгаа эмчилгээний гэж хэлж болох өвс ургамлаас таалагдсаныг нь шилж сонгон идээшилж, цэвэр цэнгэг ус ууж явдаг учир мах нь амт

чанарын хувьд онцгой сайн байдаг гэсэн дүгнэлт судлаачид хийжээ. Сүүлийн үед дэлхий дахинаа үүнийг мэддэг болж, бэлчээрийн малын мах сонирхогчид нэмэгдэх хандлагатай байна.

Судлаачдын үзэж байгаагаар эхний ээлжинд экспортын бүх махыг үйлдвэрлэлийн аргаар бэлтгэх, улмаар Улаанбаатарын зэрэг төвлөрсөн хэрэгцээний махыг ойрын хугацаанд үйлдвэрлэлийн аргаар, газар дээр нь буюу малчдад ойр бүсүүдэд бэлтгэх шаардлагатай ажээ. Ингэснээр хөдөөд ажлын байр олноороо бий болж, малын арьс ширээс эхлээд гарах түүхий эдийг технологийн дагуу бэлтгэж, аж үйлдвэрт, экспортод нийцэх чанартай түүхий эд болно гэдгийг судалгаа харууллаа. Орчин цагийн иж бүрэн хэмжээний багахан махны үйлдвэр барихад газар дээрээ 80 орчим ажлын байр бий болно гэдгийг махны үйлдвэрлэлийн судлаачид ярьж байх юм.

Бэлчээрийн МАА-г хөгжүүлэх, малын мах, арьс шир, ноос ноолуур боловсруулах шилдэг технологи эзэмшин, дэлхийн зах зээлд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох нь стратегийн зорилт болжээ.

Нөгөө нэг том зорилт бол уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан дэд бүтцийг хөгжүүлэх, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах явдал юм.

Орчин цагт мэдлэг, өндөр технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бага ч гэсэн нэмэгдэх хандлагатай боллоо. Үүнийг дэмжиж, дунд, урт хугацаандаа улс орны хөгжлийг хөтлөх бас нэг жигүүр болгох нь чухал болно.

Том зургаар харж, эдгээр зорилтыг хэрэгжүүлж чадвал Монгол Улс үйлдвэржүүлэлтийн процесс, түүний дотор бэлэн бүтээгдэхүүний экспортын үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломжтой болно.

Ийм боломжийг тааламжтай, нээлттэй болгохын тулд түнш орнууд, олон улсын байгууллагуудаас Монголд олгож буй гааль, худалдаа, хөрөнгө оруулалтын нөхцөл, бодлогын зөвлөмж, техникийн туслалцаа маш чухал билээ. Юуны түрүүнд олон улсын эрх зүйн орчныг товчхон авч үзье.

### ***Хууль эрх зүйн орчин***

Өдгөө манай гадаад худалдаа, хамтын ажиллагааны хүрээнд гааль, худалдаа, тарифын дараахь хэлэлцээрүүд үйлчилж байна. Үүнд:

#### ***Нэг. Хоёр хөрш***

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаандаа дэлхийн зах зээлийн үнэ, чөлөөт хөрвөх валют ашиглах, харилцан бие биендээ үндэсний нэн тааламжтай нөхцөл олгох зарчмуудыг Монгол Улс ба Хятад (1991 оны Худалдааны хэлэлцээр), Монгол Улс ба Орос (1993 оны Худалдаа, эдийн засгийн ажиллагааны тухай Засгийн газар хоорондын протокол) тохирч, улмаар дээд хэмжээний гэрээгээр баталгаажуулсан байна.

#### ***Хоёр. Гуравдахь хөршүүд***

Түнш орнууд, ОУБ-ууд Монгол Улсад хөгжлийн албан ёсны тусламж олгож ирсний зэрэгцээ, гаалийн болон тарифын таатай орчин бүрдүүлж байна. Тухайлбал, Манай

улсаас хоёр талаараа Европын холбоотой (2007 оноос GSP+ тогтолцоогоор 7,200 гаруй бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй экспортлох) болон Японтой (2016 оноос Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр) байгуулсан хэлэлцээр нь далайд гарцгүй Монгол Улсаас дэлхийн бусад оронтой чөлөөт худалдааны зохицуулалт хийх үлгэр загвар болжээ. Мөн худалдаа, хөрөнгө оруулалтыг хамгаалах, давхар татвар ногдуулахгүй байх асуудлаар олон арван хэлэлцээр байгуулан, худалдаа хөрөнгө оруулалтыг урамшуулж ирлээ.

АНУ, Европын холбоо 1990-ээд үед нэг хэсэг хугацаанд Монголын оёмол болон нэхмэл бүтээгдэхүүнийг тооны болоод гаалийн хязгаарлалтгүй болгосон нь тухайн үед олон тооны ажлын байр бий болгож, экспортыг нэмэгдүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ байлаа.

Монгол Улс олон улсын санхүү (ОУВС, Дэлхийн банк, АХБ-д 1991 онд) худалдаа (ДХБ-д 1997 онд)-ны байгууллагуудад гишүүн болсон явдал нь тус орны хувийн хэвшилд тулгуурласан эдийн засагт асар их түлхэц өгчээ.

Монгол Улс Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн орнууд, БНСУ-тай худалдааны хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлсэн, АНУ «Гуравдахь хөршийн бодлого»-ын хүрээнд Монголын зарим бараанд тодорхой хөнгөлөлт үзүүлэх талаар ярилцаж байгаа тухай мэдээлэл байна. Гагцхүү эдгээрийг ажил хэрэг болгож, түргэтгэх талаар манай талаас илүү санаачилгатай, мэргэжлийн түвшинд, хурдтай, сэтгэл өгч ажиллах хэрэгтэй гэсэн шүүмж гарч байна.

### ***Гааль, худалдааны тарифын түвшин***

Гааль, худалдааны татварын хувьд, дээр хэлсэнчлэн, ЕХ, Японы зах зээл манай орны ихэнх бүтээгдэхүүнд гаалийн татваргүй болсон. Манай худалдааны түншүүд үндэснийхээ нэн тааламжтай нөхцөл олгосон.

Гаалийн тарифын судалгааны дүнгээс үзэхэд бүх төрлийн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үндсэндээ манай гол түншүүдэд татваргүйгээр ордог байна. Бэлэн бүтээгдэхүүний хувьд тодорхой хэмжээний гаалийн татвар байна. Тухайлбал, ОХУ манай сүлжмэл хувцас эдлэлд 10%, хивсэнд 20%, мах, махан бүтээгдэхүүнд 25%-н татвар ногдуулж байна ([Хүснэгт №6](#)). Хятадын хувьд АНУ зэрэг том түншүүдтэйгээ хийж буй худалдааны шинэчилсэн хэлэлцээрийн хүрээнд тарифын хэмжээг багасгаж байгаа. Монголын хувьд ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний хувьд тарифын түвшин 5-6% орчимд байх төлөвтэй байна. Эдгээрээс гадна нэмүү өртгийн татвар байгаа.

Хятад ердийн НӨАТ 13-18%, ОХУ ердийн НӨАТ 20% байна. Эдгээр нь Европын орнуудын төвшинтэй ойролцоо гэж ойлгогдохоор байна ([Хүснэгт №7](#)).

Монголоос оруулах ялангуяа МАА, эрдэс түүхий эдийн эцсийн бүтээгдэхүүнийг БНХАУ, ОХУ-д гаргах гааль худалдааны тааламжтай орчин бүрдвэл, эдгээр орны иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээг хангаад зогсохгүй, Монголд хөрөнгө оруулж, үйлдвэрлэл явуулах сонирхолтой болох юм. Тухайлбал үндэстэн дамнасан томоохон компаниуд

Монголд хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэл явуулан Хятад, ОХУ гэсэн 2 том зах зээлд бараагаа гаргах илүү боломжтой болно.

### ***Тээвэр, транзит тээврийн орчин***

Өргөн уудам нутагтай Монгол Улсын тээвэр, ложистикийн нөхцөл байдал Монгол орны төдийгүй хоёр хөршөөр дамжуулан худалдаа хийхэд нэн чухал.

БНХАУ болон ОХУ хоёр талын болоод олон талын гэрээгээр Монголын транзит барааг чөлөөтэй нэвтрүүлэх үүрэг хүлээдэг байна.

БНХАУ Хятадын чиглэлд экспортолж буй Монголын талын нийт бараа бүтээгдэхүүний гуравны нэгтэй тэнцэхүйц хэмжээний ачааг гуравдагч орон руу БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх тээвэрлэлтийн хүчин чадлаар хангахаар тохирсон.

Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол, Хятадын засгийн газар хоорондын 2014 оны 8 дугаар сарын 21-ний хэлэлцээрээр Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын “Нэгдсэн нэвтрэх тариф”-аас 40-50%-н хөнгөлөлт үзүүлэхээр болсон.

Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хэлэлцээрээр манай улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг ОХУ-ын нутгаар дамжуулан төмөр замаар тээвэрлэж гуравдагч зах зээлд гаргах тохиолдолд 25 жилийн хугацаанд тогтвортой тарифын хөнгөлөлт эдлэх юм<sup>1</sup>. Энэ тарифын хөнгөлөлт 52% байх юм гэж ойлгож байгаа.

## **СОРИЛТ, ХҮНДРЭЛҮҮД, ШИЙДЭЛ**

### ***Бүтээмжтэй ажлын байрны хэрэгцээ өсөж байна.***

Бүтээмжтэй, орлого сайтай ажлын байр нэн чухал байна. Судалгаанаас үзэхэд, 900 мянган төгрөгнөөс бага цалинтай ажиллагсад нийт хөдөлмөр эрхлэгчдийн ихээхэн хувийг эзэлж байна.

Ажлын байрыг илүүтэй, харьцангуй тогтвортой хангадаг салбар нь ХАА, түүний дотор МАА, мөн тэдгээрийг түшиглэсэн салбарууд билээ.

Мал аж ахуй манай орны 170-аад мянган малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр төдийгүй хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний олон арван мянган ажлын байр бий болгодог нийгмийн том ач холбогдолтой салбар юм.

Өдгөө олонхи бизнес эрхлэгчид төрөл бүрийн бизнесийн үйл ажиллагаа оролдлого хийж зарим нь амжилтад хүрч байна. Үүний дотор малын гаралтай төрөл бүрийн бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэх нь ажлын байрны шавхагдашгүй нөөц юм. Дотоод зах хязгаарлагдмал болохоор экспортын үйлдвэрлэлд гол анхаарлаа хандуулах учиртай. Гэвч ажлын байрны ихэнхийг хангах боломжтой экспортын эцсийн

<sup>1</sup> <http://mrttd.gov.mn/single/190/item/1526>

бүтээгдэхүүний үйлдвэрлэл дорвитой хөгжихгүй байгаагаас голчлон үүсэлтэйгээр бүтээмж муутай хөдөлмөр эрхлэлт Монгол Улсын эдийн засагт давамгайлсан хэвээр байна.

### ***Бэлдсэн мэргэжилтнүүдээ ашиглах шаардлага бас бий***

Манай түнш орнууд монголын залуу үеийг сургаж, олон арван мянган боловсон хүчин бэлтгэн өгч байна. Монгол өөрөө олон оюутан сурагчидтай орон. Түүний дээр БНСУ, Япон, Чех, Унгар, Швед, Англи, Герман зэрэг Ази, Европын орнууд монголчуудыг ажил хөдөлмөр эрхлүүлж туршлагажуулж байна. Тэнд суралцсан хүмүүс найдвартай аж ахуй аваад явах арга ухаанд суралцаж ирж байна.

Ийм амжилт байгаагийн зэрэгцээ гадны мэргэжилтнээс сурах явц нэн удаан байна. Гадаадын техникийн туслалцаа, төрөл бүрийн зуучлах үйлчилгээ, зураг төсөл, ТЭЗҮ, аудит, санхүү, эдийн засгийн судалгаа зэрэгт жил бүр 200-300 сая ам доллар зарцуулж байгаа нь төлбөрийн балансаас харагдаж байна. Иймээс үйлдвэрлэл, газар дээрх сургалт удаан, урсгалаар явдаг байж болох хардалт байна. Дээрх байдлаас дүгнэвэл, хөрөнгө оруулагчид Монголын инженер, техникийн болон судлаачдын чадавхийг дээшлүүлэхэд илүү анхаарах шаардлагатай ажээ.

Үүнийг шийдэх үүднээс манай зарим түншүүд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажилд ихээхэн чармайлт гаргаж байгааг сэтгэл хангалуун ажиглаж байна. Тухайлбал Германы (German-Mongolian Institute for Resources and Technology – GMIT), Японтой хамтарсан “1000 инженер” бэлтгэх хөтөлбөр зэргийг дурдаж болно.

### ***Дэд бүтцийн сул хөгжил хамгийн том сорилт***

Монгол Улсын төлбөрийн үйлчилгээний тэнцлээс үзэхэд 3.1 тэрбум долларыг гадагш алдаж байна (Хүснэгт №7). Үүний нилээдгүй хэсэг нь зээлийн хүүний төлбөр боловч Монголын талын дэд бүтцийн сул талаас үүдэлтэйгээр ихээхэн хөрөнгө гадагш урсаж байна. Монголын шинээр үүсч буй уул уурхайн салбарын хатуу болон зөөлөн дэд бүтэц нэн дутагдалтай хэвээр байна. ТТ, ОТ зэрэг Говийн бүсэд төмөр зам бариагүйгээс асар их хэмжээний хөрөнгө гадагшилж байна. Манай төлбөрийн тэнцлийн үйлчилгээний балансыг харахад жилдээ бараг 915 сая ам.долларыг тээврийн хөлсөнд гадагш нь төлж байна. Үүний дийлэнх хэсэг нь автозамын тээвэрт ногдож байна. Мөн цахилгаан хүрэлцээгүйгээс Өмнийн Говийн ордууд 2018 оны байдлаар 114.7 сая долларын цахилгаан импортолж байна ([Хүснэгт №8](#) - тээвэр, [Хүснэгт №9](#) - цахилгаан). “Долоо хэмжиж, нэг удаа таслана” гэдгийн үлгэрээр төмөр зам, цахилгаан станца барина гэж удаан ярьцгаалаа.

### ***Дотоод нөөц бололцоог дайчлах нь бас нэг сорилт***

Зах зээлийн харилцааны эхний жилүүдэд гаднаас зээл тусламжийг эрхэмлэдэг соёлыг халах талаар нийгмийн зөвшилцөлд хүрсэн гэж ойлгож байлаа. Гэвч энэхүү хандлага маань зарим нэгэн шалтгааны улмаас алдагдаж, дотоод боломжоо анзаарч, дайчлахын оронд бэлэнчилж гадаадын зээл тусламж хүсэх “соёл”-д эргээд автах шинж байна.

Тийм учраас аливаа зээл тусламжийг авч ашиглахдаа наад зах нь дотоодод бий болсон потенциалыг яаж ашиглах тухай бодож байх хэрэгтэй болжээ.

Бид сүүлийн жилүүдэд зарим үйлдвэрлэлийн хүчин чадал бий болгожээ. Тухайлбал, цемент, барилгын хийц хэсгүүд, хөнгөн үйлдвэр, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт, хөгжлийн тусламжийг ашиглахдаа Монголоос хийх худалдан авалтыг илүүтэй нэмэгдүүлэх боломж харагдаж байна. Зээл тусламж зохицуулагч Гадаад харилцааны яам, Сангийн яам, хүлээн авагч яам газрууд зээл тусламжийн гэрээ хэлцэл байгуулахдаа Монголын бараа бүтээгдэхүүн ашиглан худалдан авах талаар холбогдох заалт оруулах талаар тусгахад анхаарч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Манай донор орнууд, олон улсын байгууллагууд үүнд анхаарч, аль болох орон нутгийн хүн хүч, материалыг зээл тусламжийн хөрөнгөөр худалдаж авч байвал томоохон дэмжлэг болох юм.

Манай хамгийн том донор АХБ-ны худалдан авах журамд орон нутгийн ажиллах хүчин, орон нутгийн материал, ноу-хау, тухайн орон нутгийн худалдааны тэмдэгтийг ашиглах давуу эрхийг тусгасан байдаг нь сайшаалтай хэрэг.

### ***Санхүүгийн нөөц ашиглах сорилт***

Аливаа төсөл хөтөлбөрийг Монголынхоо банк, санхүүгийн дотоод зах зээлээс бүрдүүлэх арга хэлбэрийг хайхын оронд “өндөр хүүтэй, хугацаа богино, хэмжээ бага” гэдэг болон бусад шалтгаанаар зайлсхийж, олон улсын санхүүгийн зах зээлээс хөрөнгө босгох, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалт авах тухай шийдвэр гаргаж, хэрэгжүүлж чадахгүй цаг алдаж байна.

Дотоодод байгаа хязгаарлагдмал санхүүгийн нөөц(пүүс, компани, үйлдвэрийн газрын чөлөөт хөрөнгийн үлдэгдэл, арилжааны банкны зээл, хөрөнгийн зах зээлийн боломж, төсвийн хөрөнгө, төв банкны эх үүсвэр, хөгжлийн банк, хөрөнгө оруулалтын сан)-ийг оновчтой ашиглахын тулд үйлдвэрлэл, хөгжил, хөрөнгө оруулалтын бодлого, стратеги, сан, мөнгөн, бас зээлийн харилцан уялдаатай бодлого зохицуулалт хийж байх нь нэн чухал. Наад зах нь дээр дурдсан дотоодод бий болсон үйлдвэрлэлийн хүчин чадлыг хөрөнгө оруулалт, банкны зээл, хөгжлийн санхүүжилтээр дамжуулан ашиглах талаар нэгдсэн бодлоготой байж чадаж байна уу. Дотоод нөөц боломжоо гадны зээл, хөрөнгө оруулалттай холбох талаар санаачилгатай баймаар байна.

Дэлхий дахины хөгжлийн манлайд хүрсэн орнуудын экспортыг дэмждэг арга механизм(экспортын зээлийн сан, даатгал, хүү, гааль, татварын хөнгөлөлт,)-г зөв бодлоготойгоор бүрдүүлэх нь чухал байна.

Монгол Улсын экспортыг түнш орнуудад гаргахад тарифын болон тарифын бус ямар хөнгөлөлт үзүүлэх, нөгөө талаас Монгол Улс экспортоо хэрхэн дэмжих тухай ярихыг Та бүхнээс хүсэж байна.



Монгол Улс түүхий эдээ хавчигдмал цаг хугацаанд бэлтгэж авдаг боловч түүнийхээ дийлэнхийг экспортолж, олон улсын зах зээлд гаргахад удаан хугацааны үйл ажиллагаа шаардагддаг. Иймээс аливаа татвар, зээлийн хөнгөлөлтийг эрэмбэлэхдээ экспортод гаргах шалгуурыг нэг номерт тавьдаг олон улсын шилдэг туршлагыг Монголын хөрсөнд буулгах, магадгүй экспортыг дэмжсэн байнгын хөшүүрэг, хөрөнгө мөнгө бүхий хөгжлийн сан, санхүүгийн механизм, хөнгөлөлтүүд бий болгож, хуульчлах шаардлага ч байж магадгүй.

Чингэхдээ эрдэс түүхий эд, ялангуяа шавхагддаг байгалийн баялгийг олборлож аваад, гадагш гаргахад тусгайлсан хөнгөлөлт үзүүлж болохгүй гэдэг сургамжийг бид авсан. Гагцхүү ажлын байр, техник технологи үр чадвар бий болгодог, нэн ялангуяа жил бүхэн өсөн үржиж сэргэж байдаг МАА-н түүхий эдийг боловсруулах, мэдлэг оюуныг хөгжүүлэх зориулалттай хөрөнгө оруулалтад бүх төрлийн хөнгөлөлт дэмжлэгийг олгох тухай ярьж байгаа юм.

Монгол Улсын томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх чиг үүрэг бүхий Хөгжлийн банк нь эхний ээлжинд Монгол Улсын уул уурхайн боловсруулах үйлдвэр, холбогдох дэд бүтэц, түүнчлэн агро-аж үйлдвэрийн комплексийг санхүүжүүлэх зориулалт бүхий хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах үүрэг авсан гэж ойлгож байгаа. Энэ талаарх илтгэлийг тусад хэлэлцэх хуваарьтай.

Монгол Улс бол гаалийн тарифын хувьд бараг чөлөөт худалдааны хүрээнд хэрэглэдэг тарифтай орон.

## **САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Нэг. Мал аж ахуй. МАА-н түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгон, гадаад дотоодын зах зээлд гаргахын тулд манай талаас олон суурь асуудлууд ( тухайлбал, мал эрүүлжүүлэх, тоо толгойг нь бэлчээрийн даацад нийцүүлэх, түүхий эд бэлтгэлийн шинэ арга замыг олох, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх)-дад анхаарал тавих зүйн хэрэг ээ. Эдгээрийг эцсийн үр дүнд хүргэхэд юуны өмнө мал аж ахуйн экспортыг бүх талаар дэмжиж, үр дүнд хүрэхээс хамаарна. Үүний тулд:

Мал аж ахуйн экспортыг дэмжих хөрөнгө оруулалтын стратеги гаргах. Жишээлбэл, ирэх 5 жилд (ойрын дунд хугацаанд), махыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, түүхий эдийг наад зах нь хагас бэлэн бүтээгдэхүүн болгох суурь бий болгох. Тухайлбал, Ноолуураар бүх төрлийн утсыг хийдэг болох, арьсны хувьд – бэлэн арьс краст, торгон арьс болтол боловсруулах. Ингэсэн нөхцөлд эдгээр хагас боловсруулсан бүтээгдэхүүн утас, крастад дотоод гадаадын зах зээл олдоно гэдгийг мэргэжлийн хүмүүс зөвлөж байгаа юм. Малчид арьс, шир үнэд хүрвэл тэдгээрийг чанартай бэлтгэж чадна гэдэг. Чөлөөт өрсөлдөөнийг хааж болох аливаа хэлбэрээс зайлсхийх буюу малчдад илүүтэй орлого олох илүү боломж гаргах, нийлүүлэлтийн нэмүү өртгийн сүлжээг дэмжих явдал ажээ. Эдгээрт чиглэсэн бодлого, стратеги хэрэгтэй гэсэн үг.

Хоёр. Уул уурхайн дэд бүтцийг хөгжүүлэх бодлогоо тууштай мөрдөж, ялангуяа төмөр зам, цахилгаан станц зэрэг дэд бүтцэд онцгой анхаарах. Зарим эрдэс түүхий эдийг

боловсруулж, дотоод гадаадын хэрэгцээ хангах боломжийг хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийнхэнд илүүтэй олгох. Уул уурхайн хувьд санхүүжилт, өмчлөл, байгаль орчин, техник технологи, боловсон хүчний хангамж, олон улсын зах зээлд гарах асуудлыг иж бүрнээр нь, бодитойгоор гаргаж тавьж, нэгдсэн ойлголтод хүрч чадахгүй удах явдал байгаа юм. Ийм нөхцөлд хэрхэн яаж ажиллах талаар манай түнш орнууд, ОУБ-ын дуу хоолой чухал байх болно. Уул уурхай тойрсон популизмыг гаргахгүй байх нь нэн тэргүүний зорилт.

Гурав. Шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагааг практик төвшинд гаргах явдал болно. Судалгаа, хөгжлийг дэмжих, ялангуяа лаборатори, туршилт явуулах үйлдвэр цех байгуулах ажлыг бүх талаар дэмжих. 2025 оноос цааших жилүүдэд мэдлэг, технологид суурилсан үйлдвэрлэл, гадаад худалдаа, өндөр технологийн хамтын ажиллагаа давамгайлах болтугай гэсэн санаа. Тэр болтол уул уурхайн бүтээн байгуулалт (ОТ-н гүний уурхай 2023 онд, ТТ-н төмөр зам 2022 дуусна гэж тооцвол) зэрэг дэд бүтцийн хөгжил эдийн засгийн хөгжлийн манлайлагч байх юм.

Дөрөв. Европын холбоо болон Япон Улс шиг манай барааг гаальгүй оруулдаг жишгийг манай бусад гол түншүүд анхаарч, Монголын барааг гаальгүй оруулдаг болохыг хүсэж, санал болгож байна. Ийм гаалийн хязгаарлалтгүй дэглэмийг хөгжиж байгаа Монгол Улсад эдлүүлэх нь ДХБ-ын зарчмууд, хэлэлцээрүүд дэх боломж олгох заалтууд (Enabling clauses)-тай бүрэн нийцэх бөгөөд том эдийн засагтай БНХАУ зэрэг орнууд заавал чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулна гэж хүлээлгүй дангаараа шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Тав. Мөнгө, төсөв, зээл хөгжлийн бодлого нь төлбөрийн тэнцлээ дэмжиж, экспортын үйлдвэрлэл үйлчилгээг, нэмүү өртгийн сүлжээг урамшуулах, валютын үрлэгэн тээвэр, ложистикийн бүтцэд өөрчлөлт, хувьгал хийх хэрэгтэй байна. Үүнийг биднийг дэмжигчид, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид анхаардаг болох явдал нэн чухал бөгөөд Монголын онцлог юм гэдгийг дээр олон дахин давтан ярьлаа. Монгол Улс экспортын үйлдвэрлэлийг дэмжиж, ХАА-н түүхий эд, эрдэс баялгаас эцсийн бүтээгдэхүүн гаргах санаачилгыг олон талаар дэмжиж ажиллах хэрэгтэй ба ялангуяа хамгийн бодит дэмжлэг болох санхүүжилтийн механизмыг бий болгоход онцгой анхаарах нь чухал байна.

Энэ санг бүрдүүлэхэд олон улсын санхүүгийн байгууллагууд, донор орнуудын санал санаачилга, туршлага, хувь нэмэр нэн чухал байна. Энэ талаар та бүгд санаа бодлоо манай төрийн байгууллагуудтай хуваалцаж, дэмжлэг үзүүлэх чиглэл гаргавал таатай байх болно. Дэс дараатай санхүүжилт, нэг удаагийн алхмаар шийдэхгүй бөгөөд аажим аажмаар шийдэх биз ээ. Тухайлбал 200 сая орчим ам долларын эргэлтийн сан байгуулж, МАА-н бүтээгдэхүүний экспортын төрлийг дэмжих боломжтой гэсэн тооцоо байгаа юм.

Валют олох, экспорт, хөрөнгө оруулалтыг дэмжинэ гэдэг эдийн засгийн нэг номерын асуудал гэдгийг гааль, татвар, мэргэжлийн хяналт, аудит, ГХЯ, Сангийн болон салбарын яам, газруудын ажилтнууд, төрийн бус зарим байгууллагуудын зүгээс ойлгох, тэдэнд ойлгуулах шаардлагатай гэдэг нь судалгаагаар, уулзалт ярилцлагаас харагдаж байгаа.

Гагцхүү аливаа асуудал, ялангуяа гадаад худалдаа, хөрөнгө оруулалт тойрсон үйл явцыг зөвхөн хууль дүрэм, олон улсын гэрээ хэлцлийн хүрээнд шийдэгдэнэ гэсэн хүлээлтийг бий болгож, үр дүнд хүргэдэг байх тийм соёлыг түншүүд, хөрөнгө оруулагчид та бүхэнтэй хамтран Монголын бизнесийн орчинд бүрдүүлж суулгах шаардлагатай байна. Та бүхний санал зөвлөмж нэн чухал юм.

## Хавсралтууд

### Хүснэгт №1: Гадаад худалдааны нийт бараа эргэлт

(мян.ам.доллар/thous.USD)


Үзүүлэлт	Description	2017 он	2018 он	Харьцуулсан хувь (%)
<b>НИЙТ БАРАА ЭРГЭЛТ</b>	<b>TOTAL FOREIGN TRADE TURNOVER</b>	<b>10,537,915.4</b>	<b>12,886,561.6</b>	<b>122.3</b>
<b>А.Экспорт</b>	<b>A.EXPORT</b>	<b>6,200,593.0</b>	<b>7,011,757.8</b>	<b>113.1</b>
1.Валютын төлбөртэй бараа	1.Trade paid in hard currency	6,075,342.3	6,953,876.9	114.5
2.Боловсруулсан бараа	2.Processed goods	5,368.6	4,017.0	74.8
3.Тусламжийн бараа	3.Aid commodity supplied	0.0	40.7	0.0
4.Төлбөрт зориулсан бараа	4.Commodity for payment	59,420.7	0.0	0.0
5.Реэкспорт	5.Re-export	57,407.5	53,612.1	93.4
6.Бусад	6.Other	3,053.8	211.1	6.9
<b>Б.Импорт</b>	<b>B.IMPORT</b>	<b>4,337,322.4</b>	<b>5,874,803.8</b>	<b>135.4</b>
1.Валютын төлбөртэй бараа	1.Trade paid in hard currency	4,025,661.9	5,452,522.3	135.4
2.Бараа солилцоо	2.Barter trade	533.3	436.3	81.8
3.Тусламжийн бараа	3.Aid commodity supplied	21,531.9	61,694.3	286.5
4.Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа	4.Commodities imported as investment	206,358.3	176,786.4	85.7
5.Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа	5.Commodity supplied by loan	55,742.3	161,705.2	290.1
6.Боловсруулсан бараа	6.Processed goods	20,292.3	12,386.5	61.0
7.Реимпорт	7.Re-import	4,877.9	6,164.6	126.4
8.Бусад	8.Other	2,324.5	3,108.2	133.7
<b>В.Сальдо(А-Б):</b>	<b>C. Balance(A-B)</b>	<b>1,863,270.6</b>	<b>1,136,954.0</b>	<b>61.0</b>
<b>Г.Импортыг экспортоор нөхөх коеф ((А/Б)*100)</b>	<b>D. index(A/B)*100</b>	<b>143.0</b>	<b>119.4</b>	<b>83.5</b>

**Хүснэгт №2: Монгол Улсын төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)**

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>-342</b>	<b>-885</b>	<b>-4,512</b>	<b>-5,381</b>	<b>-4,732</b>	<b>-1,934</b>	<b>-948</b>	<b>-700</b>	<b>-1,155</b>	<b>-2,207</b>
Орлого	2,583	3,733	5,050	5,020	4,886	6,468	5,515	5,978	7,141	8,461
Зарлага	2,925	4,618	9,563	10,400	9,618	8,402	6,463	6,678	8,297	10,668
<b>1.А Бараа ба үйлчилгээний худалдаа</b>	<b>-332</b>	<b>-475</b>	<b>-3,517</b>	<b>-4,456</b>	<b>-3,918</b>	<b>-1,111</b>	<b>-153</b>	<b>0</b>	<b>278</b>	<b>-1,303</b>
Орлого	2,298	3,394	4,577	4,452	4,478	6,078	5,135	5,605	6,801	7,668
Зарлага	2,630	3,869	8,094	8,908	8,396	7,189	5,288	5,605	6,523	8,971
<b>1.А.а Бараа</b>	<b>-178</b>	<b>-172</b>	<b>-2,669</b>	<b>-3,030</b>	<b>-2,608</b>	<b>178</b>	<b>563</b>	<b>1,338</b>	<b>1,490</b>	<b>676</b>
Экспорт	1,881	2,908	4,056	3,800	3,789	5,471	4,446	4,804	5,834	6,557
Импорт	2,059	3,080	6,725	6,830	6,397	5,293	3,884	3,466	4,345	5,881
<b>1.А.б Үйлчилгээ</b>	<b>-154</b>	<b>-303</b>	<b>-848</b>	<b>-1,426</b>	<b>-1,310</b>	<b>-1,289</b>	<b>-715</b>	<b>-1,338</b>	<b>-1,212</b>	<b>-1,978</b>
Орлого	418	486	521	652	689	607	689	801	966	1,112
Зарлага	571	789	1,369	2,077	1,999	1,896	1,404	2,139	2,178	3,090
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	<b>160</b>	<b>152</b>	<b>130</b>	<b>142</b>	<b>141</b>	<b>136</b>	<b>116</b>	<b>91</b>	<b>78</b>	<b>92</b>
Орлого	160	153	134	144	143	136	117	94	82	93
Зарлага	0	1	4	2	2	1	1	3	4	2
<b>Урсгал болон хөрөнгийн данс</b>	<b>-181</b>	<b>-733</b>	<b>-4,382</b>	<b>-5,238</b>	<b>-4,591</b>	<b>-1,799</b>	<b>-833</b>	<b>-609</b>	<b>-1,078</b>	<b>-2,115</b>

Эх сурвалж: Монголбанк

График №1



**Хүснэгт№3: НИЙТ ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК, Салбараар (мянган ам.доллар)**

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Засгийн газар	1,882,167.8	2,043,338.7	3,599,340.8	3,534,577	3,500,795	3,759,859	4,868,606	7,320,975	7,184,193
Төвбанк	273,602.4	267,689.0	571,488.7	1,130,456	1,570,355	1,959,643	1,790,751	2,025,079	2,030,222
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	512,018.1	739,836.7	1,176,045.3	1,375,810	1,762,182	2,128,504	2,417,380	2,194,264	2,230,371
Бусад салбарууд	1,474,276.2	1,904,686.6	2,836,099.5	3,198,699	3,976,579	3,748,947	8,121,485	7,955,844	8,041,874
<b>Нийт гадаад өр</b>	<b>7,127,788.7</b>	<b>10,908,305.8</b>	<b>17,210,529.5</b>	<b>19,829,657</b>	<b>21,850,516</b>	<b>22,717,817</b>	<b>24,624,500</b>	<b>27,492,657</b>	<b>28,714,887</b>
Үүнээс: Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	2,985,724.2	5,952,754.8	9,027,555.2	10,590,115	11,040,606	11,120,864	7,426,277	7,996,494	9,228,228

Эх сурвалж: Монголбанк

График№2



**Хүснэгт №4: Засгийн газрын гадаад зээлийн 2015-2018 оны жилийн эцсийн үлдэгдэл**

<i>(тэрбум төгрөгөөр)</i>					
	<b>Зээлдүүлэгч гадаад орон, Олон Улсын байгууллага</b>	<b>2015 он</b>	<b>2016 он</b>	<b>2017 он</b>	<b>2018 он</b>
1	Япон	988.9	1,568.4	2,580.9	2,895.2
2	Солонгос	98.4	168.4	192.1	339.2
3	Хятад	718.1	1,091.3	1,232.7	1,823.7
4	Герман	197.2	242.8	263.4	284.2
5	Азийн Хөгжлийн банк	1,327.7	1,804.1	2,430.9	3,250.1
6	Дэлхийн банк	869.0	1,050.0	1,398.9	1,500.6
7	Нордикийн хөгжлийн сан	53.6	62.2	64.4	65.5
8	Арабын Эдийн засгийг хөгжүүлэх Кувейтын сан	83.8	96.8	85.3	81.9
9	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	45.2	56.9	61.0	68.0
10	Абу-Даби сан	12.2	13.5	11.4	10.5
11	Испани	16.2	17.0	16.2	14.1
12	Итали	-	-	-	-
13	Олон Улсын Валютын сан	-	-	-	-
14	Франц	31.9	38.9	43.3	43.7
15	Финлянд	-	-	-	-
16	Бельги	10.0	12.0	13.3	13.9
17	Болгар	-	-	-	-
18	Энэтхэг	53.5	67.7	66.5	74.4
19	Польш	0.1	-	-	-
20	Орос	-	-	-	-
21	Швед	4.7	5.0	4.0	3.3
22	Австри	54.6	86.0	103.7	140.9
23	Европын хөрөнгө оруулалтын банк	-	5.2	5.8	21.2
24	Швейцарын Кредит свисс банк	-	597.5	582.5	570.9
	<b>Нийт дүн</b>	<b>4,565.1</b>	<b>6,983.7</b>	<b>9,156.3</b>	<b>11,201.3</b>

Эх сурвалж: Сангийн яам

**Хүснэгт №5: МАА-н гаралтай түүхий эдээр нөөц бэлтгэх хөрөнгө, 2018 оны үнээр**

<b>Хүснэгт Б.1.</b>			
<b>МАА -Н ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДЭЭР НӨӨЦ БЭЛТГЭХ ХӨРӨНГӨ, 2018 ОНЫ ҮНЭЭР</b>			
<b>Хөнгөн үйлдвэрийн салбарууд</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо хэмжээ /тн/</b>	<b>Шаардлагатай хөрөнгө /тэрбум төг/</b>
1. Ноолуур боловсруулах	тн	10,945.1	985.1
2. Ноос боловсруулах	тн	37747.7	132.3
3.Мах боловсруулах	мян тн	197.3	1,368.6
4.Арьс шир боловсруулах	мян ш	15410.7	231.9
<b>Нийт дүн</b>			<b>2,717.8</b>

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

**Хүснэгт №6: ОХУ: МУ-ын гол нэрийн экспортын бараанд ногдуулж гаалийн татвар**

Барааны код	Барааны нэр	Тариф		
		Ердийн	MFN	GSP
2529	Жонш	26	13	-
020220	Үхрийн хөлдүү мах	65	32,5	24,38
020500	Адууны шинэ, хөргөсөн ба хөлдүү мах	50	25	18,75
510121	Сэмлээгүй буюу самнаагүй хонины ноос	10	5	3,75
271600	Цахилгаан эрчим хүч	0	0	0
611012	Сүлжмэл хувцас, эдлэл	20	10	-
270112	Битумжсан нүүрс	5	2,5	-
1602	Мах, дайвар мах болон цусаар хийсэн бусад бэлдмэл, тэдгээрийн лаазалсан бүтээгдэхүүн	50	25	18,75
270119	Чулуун нүүрс	10	5	-
570241	Хивс	40	20	-
220860	Цагаан архи	112,56	56,28	-
630120	Хонины ноосон буюу мал, амьтны нарийн үс, ноосон хөнжил, аяны хөнжил	40	20	-
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас, адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу	10	5	-
220290	Согтууруулах биш бусад ундаа	49,57	24,79	-

Эх сурвалж: “Монгол улс, ОХУ хоорондын чөлөөт худалдааны хэлэлцээрийн төслийн үндэслэл”, ГХЯ-ны захиалгаар хийгдсэн төслийн тайлан. УБ., 2012 т.63



**Хүснэгт №7: Худалдааны зарим гол түншүүдийн НӨАТ**

Country	VAT		Which Goods and Services
	Rate	Type	
Russia	20%	Standard	All other taxable goods and services
	16.67%	Reduced	Foodstuffs; livestock; certain children's supplies; medicine; water; books
	0%	Zero	Exports and associated services; suburban rail passenger transport (until 2029)
China	13%/18%	Standard	All other taxable goods and services
	9%	Standard	Retail; entertainment; hotel; restaurants; catering services; real estate and construction, telephony calls; postal; transport and logistic
	6%	Standard	Financial services and insurance; telephony and internet data; IT; technology; consulting
	3%		Chinese National Education Tax
	2%		Chinese Local Education Taxes
	3%		Construction services
	1%-56%	Luxury	Consumption tax applies to prescribed nonessential and luxury or resource-intensive goods (including alcohol, luxury cosmetics, fuel oil, jewellery, motorcycles, motor vehicles, petrol, yachts, golf products, luxury watches, disposable wood chopsticks, tobacco, certain cell and coating products), and it mainly affects companies involved in producing or importing these goods. The tax is calculated based on the sales value of the goods, the sales volume or a combination of the two. The proportional consumption tax rate is from 1% to 56% on the sales revenue of the goods. Exports are exempt.

**Хавсралт №8: Гадаад худалдаа, тээврийн төрлөөр**

**Хавсралт 15. Гадаад худалдаа, тээврийн төрлөөр  
APPENDIX 15. FOREIGN TRADE TURNOVER, by transportation type**

код	Тээврийн төрөл	Импорт, үнийн дүн мян.дол		Экспорт, үнийн дүн мян.дол	
		2017 он	2018 он	2017 он	2018 он
20	Төмөр зам	2,468,832.9	3,256,229.2	1,599,668.7	1,840,769.7
30	Авто зам	1,386,543.9	2,103,720.3	3,928,397.3	4,946,979.7
40	Агаар	338,065.8	356,608.8	671,978.1	223,410.1
51	Шуудан илгээмж	349.1	518.5	69.5	113.1
52	Буухиа шуудан	1,449.4	1,698.1	120.0	111.1
60	Холимог тээвэр	0.0	818.4		
70	Хөдөлгөөнт бус тээвэр	141,621.3	153,539.0	359.3	374.0
90	Бусад тээврийн хэрэгсэл	460.0	1,671.5		
	<b>Дүн</b>	<b>4,337,322.4</b>	<b>5,874,803.8</b>	<b>6,200,593.0</b>	<b>7,011,757.8</b>

**Хавсралт №9: Цахилгаан эрчим хүчний импорт (мянган ам.доллар)**

2716	Цахилгаан эрчим хүч.	Electrical energy.	мян.квтц	1000 kWh	1,665,707.81	142,539.1
	БНХАУ	China			1,261,879.6	114,735.0
	ОХУ	Russian Federation			403,828.2	27,804.1

### Хүснэгт №10: ЗЭС, НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ОРЛОГО, ТОО ХЭМЖЭЭ

Статисти к үзүүлэлт	Гол нэр төрлийн бараа	2002	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Тоо хэмжээ	Зэсийн баяжмал(мян.т)	548.6	575.9	574.3	649.8	1,379	1,477.80	1,562	1,447.22	1,436.70
	Нүүрс (мян.т)	11	21,296	20,915.50	18,373.1 0	19,499	14,472.60	25,810.60	33,400.10	36,264.80
Үнийн дүн(мян.а м.долл)	Зэсийн баяжмал(мян.т)	140,232.1	968,551.40	838,579.30	948,951	2,574,706. 10	2,280,135. 30	1,607,754. 30	1,613,117. 29	2,012,194.40
	Нүүрс (мян.т)	61.3	2,273,006	1,901,773.50	1,122,03 3.50	849,039.50	555,923.20	973,072.76	2,267,642. 26	2,802,517.50

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жич: ОТ-ын уурхайн бүтээн байгуулалт дуусч бүрэн хүчин чадлаараа ажиллах 2025 оноос 2.0 сая тонноор нэмэгдэж, 3424.0 мянган тонн баяжмал болох тооцоо байна.

**Хүснэгт №11: АЖИЛЛАГЧДЫН ТОО (улирлаар)**

Үзүүлэлт	2016	2017	2018
15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо	1,132,843	1,266,942	1,256,356
<b>Салбар</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	352,021	379,806	366,544
Уул уурхай, олборлолт	41,799	55,688	60,164
Боловсруулах үйлдвэрлэл	88,614	91,216	99,985
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	15,191	16,854	18,561
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4,551	6,292	6,887
Барилга	59,078	63,060	67,341
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	172,732	207,324	207,368
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	61,603	72,398	64,262
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	34,673	36,664	33,890
Мэдээлэл, холбоо	19,400	19,062	15,176
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	23,576	24,924	22,216
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	316	818
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12,730	15,239	15,021
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	10,548	18,461	19,410
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	77,582	86,526	74,876
Боловсрол	93,221	100,458	95,499
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	37,792	39,625	48,124
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	7,956	9,125	15,825
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17,411	19,112	22,726
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	811	3,958	638
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,554	834	1,025
<b>НИЙТ</b>	<b>1,132,843</b>	<b>1,266,942</b>	<b>1,256,356</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Хүснэгт №12**

1.13 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн 4 дүгээр улирлын байдлаар

Цалин хөлсний бүлэг, төгрөг	2017		2018			
	Х-ХII		VII-IX		X-XII	
	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>613 937</b>	<b>100.0</b>	<b>651 098</b>	<b>100.0</b>	<b>652 249</b>	<b>100.0</b>
240 000 хүртэл	46 688	7.6	48 330	7.4	46 361	7.1
240 001 - 300 000	34 323	5.6	34 849	5.4	30 746	4.7
300 001 - 500 000	85 719	14.0	103 988	16.0	81 470	12.5
500 001 - 700 000	111 950	18.2	120 763	18.5	110 447	16.9
700 001 - 900 000	104 497	17.0	105 715	16.2	102 902	15.8
900 001 - 1 100 000	76 211	12.4	73 313	11.3	87 084	13.4
1 100 001 - 1 300 000	45 693	7.4	43 306	6.6	53 773	8.2
1 300 001 - 1 500 000	28 217	4.6	30 476	4.7	36 171	5.6
1 500 001 - ээс дээш	80 639	13.1	90 358	13.9	103 295	15.8
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар						